



**УЛААНБААТАР ХОТЫН
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 1/221

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл эзэмшигч “Нью проперти сервис” ХХК-тай
тооцоо хийх цэвэр, бохир усны үйлчилгээний бөөний
тариф мөрдөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, 20.1.10 дахь заалт, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 88 дугаар тогтоол, Ус сувгийн удирдах газрын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч “Нью проперти сервис” ХХК-ний цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөрийг тооцохдоо Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 88 дугаар тогтоолоор батлагдсан бөөний тарифыг мөрдсүгэй.

2. Батлагдсан цэвэр, бохир усны үйлчилгээний бөөний тарифыг 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс мөрдөж ажиллахыг Хэрэглэгчдэд үйлчлэх албаны дарга (Ц.Баянзул)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Инженерийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Одхүү), Санхүү бүртгэлийн хэлтэс (Ч.Ариунаа)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ТӨРХҮҮ